

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 7360 дугаарт бүртгэв.

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, ХОТ  
БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 9 дүгээр  
сарын 03-ны өдөр

Дугаар А/705, А/205

Улаанбаатар  
хот

**ХАЯГДАЛ УСАНД АГУУЛАГДАХ БОХИРДУУЛАХ БОДИСЫН  
ЖИШИГ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хоногт 50 шоометрээс бага, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Усны газар (З.Батбаяр), Сав газрын захиргаадад тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газар (Т.Балжинням), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар (М.Ням-Очир)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/816/218 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Б.БАТБААТАР

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН САЙД

Э.БАТ-АМГАЛАН

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын хамтарсан 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/705, А/205 дугаар тушаалын хавсралт*

**ХАЯГДАЛ УСАНД АГУУЛАГДАХ БОХИРДУУЛАХ БОДИСЫН  
ЖИШИГ ХЭМЖЭЭ**

| №              | Үйлдвэр, үйлчилгээ                                                                  | Бохирдуулах бодисын жишиг хэмжээ, кг/м³          |        |
|----------------|-------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|--------|
|                |                                                                                     | Үзүүлэлтийн нэр                                  | Хэмжээ |
| Нэг.Үйлдвэрлэл |                                                                                     |                                                  |        |
| 1              | Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн, гоймон                                     | Органик бодис (Химийн хэрэгцээт хүчил төрөгчөөр) | 5      |
| 2              | Чихэр, шоколад                                                                      |                                                  | 5      |
| 3              | Гурил, тэжээл                                                                       |                                                  | 5      |
| 4              | Ус, ундаа, жимсний шүүс                                                             |                                                  | 5      |
| 5              | Дарс, шар айраг                                                                     |                                                  | 5      |
| 6              | Архи, спирт                                                                         |                                                  | 5      |
| 7              | Мах, махан бүтээгдэхүүн                                                             |                                                  | 6      |
| 8              | Өлөн дайвар бүтээгдэхүүн, мал нядлах                                                |                                                  | 6      |
| 9              | Сүү, сүүн бүтээгдэхүүн                                                              |                                                  | 3      |
| 10             | Жимс жимсгэнэ, ногоо, самар, ургамлын тос, амтлагч                                  |                                                  | 1.5    |
| 11             | Будах, цайруулах бодис хэрэглэдэггүй ноос, ноолуур угаах цех                        |                                                  | 5      |
| 12             | Сүлжмэл, ээрмэл, оёдол                                                              |                                                  | 5      |
| 13             | Эсгий, эсгий гутал                                                                  |                                                  | 5      |
| 14             | Мод боловсруулах, цаас, целлюлоз, картон                                            |                                                  | 4      |
| 15             | Тавилгын үйлдвэр                                                                    |                                                  | 0.8    |
| 16             | Хэвлэх үйлдвэр                                                                      |                                                  | 1.5    |
| 17             | Эм, эмийн бэлдмэл                                                                   |                                                  | 3.5    |
| 18             | Саван, үнэртэн, гоо сайхан, ариутгал, цэвэрлэгээний бүтээгдэхүүн, будаг, лак, цавуу |                                                  | 3.5    |
| 19             | Эрчим хүч, дулааны үйлдвэрлэл                                                       |                                                  | 0.8    |
| 20             | Үхэр, гахай, шувууны ферм                                                           |                                                  | 6      |
| 21             | Хүлэмж                                                                              |                                                  | 0.8    |
| 22             | Арьс, шир боловсруулах үйлдвэр                                                      |                                                  | 6.5    |
| 23             | Хивс, ээрмэл, нэхмэлийн болон утас будах үйлдвэр                                    |                                                  | 7      |
| 24             | Хуванцар, нийлэг эдлэлийн үйлдвэр                                                   |                                                  | 0.8    |
| 25             | Хог хаягдал шатаах, дахин боловсруулах үйлдвэр                                      |                                                  | 0.8    |
| 26             | Бордооны үйлдвэр                                                                    |                                                  | 0.8    |
| 27             | Гальваникийн үйлдвэр                                                                |                                                  | 0.8    |
| 28             | Металл боловсруулах, машины үйлдвэр                                                 |                                                  | 0.8    |
| 29             | Хар ба өнгөт металл боловсруулах үйлдвэр                                            |                                                  | 0.8    |

|                                      |                                                                                                                                                             |                                                     |     |
|--------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------|-----|
| 30                                   | Барилгын материалын үйлдвэр, шил, шилэн материал вааран хийцийн үйлдвэр, лак будгийн материал үйлдвэрлэл, гадаргуугийн идэвхтэй синтетик материалын үйлдвэр |                                                     | 0.8 |
| 31                                   | Бусад үйлдвэрлэл                                                                                                                                            |                                                     | 0.8 |
| 32                                   | Ашигт малтмал олборлох, баяжуулах үйлдвэр                                                                                                                   | Эрдэс бодис<br>(Нийт ууссан давс, TDS)              | 15  |
| 33                                   | Газрын тосны олборлох, боловсруулах үйлдвэр                                                                                                                 | Органик бодис<br>(Өөх тос)                          | 2   |
| Хоёр.Үйлчилгээ                       |                                                                                                                                                             |                                                     |     |
| 34                                   | Хими цэвэрлэгээ                                                                                                                                             | Органик бодис<br>(Химийн хэрэгцээт хүчил төрөгчөөр) | 1.5 |
| 35                                   | Угаалгын газар                                                                                                                                              |                                                     | 1.5 |
| 36                                   | Үзвэр, худалдаа, ахуйн үйлчилгээ                                                                                                                            |                                                     | 1.5 |
| 37                                   | Нийтийн хоол                                                                                                                                                |                                                     | 1.5 |
| 38                                   | Автомашин угаалгын газар                                                                                                                                    |                                                     | 1.5 |
| 39                                   | Зочид буудал, жуулчны бааз, ажилчдын тосгон                                                                                                                 |                                                     | 1.5 |
| 40                                   | Бусад үйлчилгээ                                                                                                                                             |                                                     | 0.8 |
| Гурав.Нийгмийн үйлчилгээ болон бусад |                                                                                                                                                             |                                                     |     |
| 41                                   | Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, лабораториуд                                                                                                            | Органик бодис<br>(Химийн хэрэгцээт хүчил төрөгчөөр) | 1.5 |
| 42                                   | Бүх шатны боловсрол, халамжийн байгууллагууд                                                                                                                |                                                     | 0.8 |

## **ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 8 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 28

Рашаант

### **МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээг тэмээ-0 (Тэг) төгрөг, адуу-2000 (Хоёр мянга)-н төгрөг, үхэр-2000 (Хоёр мянга)-н төгрөг, ямаа-500 (Таван зуу)-н төгрөг, хонь-400 (Дөрвөн зуу)-н төгрөгөөр, тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварыг иргэд, малчдад сурталчилж, хугацаанд нь төсөвт төвлөрүүлж зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг сумын Засаг дарга (А.Жавхлан)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү Тогтоолыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 17 дугаар тогтоол, 2021 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 24 дүгээр тогтоолуудыг тус тус энэ өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.НАСАНБАЯР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 7362 дугаарт бүртгэв.

## **ХЭНТИЙ АЙМАГ ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 8 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 26

Өмнөдэлгэр сум

### **МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долоодугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөх малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлэн хуулийн хүрээнд зарцуулан ажиллаж тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж хорооны ажлын төлөвлөгөөнд тусган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороо (Д.Энхбаатар), Төсөв санхүү, дэд бүтцийн асуудал эрхэлсэн хороо (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

4.Тогтоолыг иргэд, олон нийтэд сурталчлан танилцуулахыг багийн Засаг дарга, Хурлын Төлөөлөгч нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/04 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Ц.ПҮРЭВДОРЖ

Өмнөдэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн долоодугаар  
хуралдааны 26 дугаар тогтоолын хавсралт

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

| Д\д | Малын тоо толгойн албан татвар<br>/тоо толгойд ногдоно/ |              | 0 төгрөг ногдох албан татвар буюу<br>малчны амьжиргааг дэмжих зорилгоор<br>хасагдах хэмжээ |            |
|-----|---------------------------------------------------------|--------------|--------------------------------------------------------------------------------------------|------------|
|     | Төрөл                                                   | Татвар /төг/ | Төрөл                                                                                      | Тоо толгой |
| 1   | Адуу                                                    | 1000         | Адуу                                                                                       | 10         |
| 2   | Үхэр                                                    | 800          | Үхэр                                                                                       | 10         |
| 3   | Хонь                                                    | 400          | Хонь                                                                                       | 100        |
| 4   | Ямаа                                                    | 700          | Ямаа                                                                                       | 100        |
| 5   | Тэмээ                                                   | 0            | Тэмээ                                                                                      | 0          |

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 7363 дугаарт бүртгэв.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар А/217

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журмыг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Ерэн-Өлзий)-т даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Бекболат)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2020 оны “Журам батлах тухай” 100 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

*Эрчим хүчний сайдын 2025 оны 9 дүгээр сарын 09-ний  
өдрийн А/217 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

## **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮҮСГҮҮР БАРИХ ТӨСӨЛ ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл (цаашид “төсөл” гэх)-ийг нийтэд зарлах, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн шалгаруулах, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журамд заасан сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл гэдэгт 6 кВ болон түүнээс дээш хүчдэлийн түвшинд сүлжээнд холбогдон үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг худалдах зорилгоор нар, салхины үүсгүүрт хөрөнгө оруулах, барих, эрчим хүчийг үйлдвэрлэн, худалдахтай холбогдсон үйл ажиллагаа хамаарна.

1.3.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл хэрэгжүүлэгч нь Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.4.Оролцогч нь төсөл шалгаруулалтад оролцох сонирхолоо илэрхийлэх, энэ журамд заасан шаардлага хангасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн түншлэл байна.

### **Хоёр.Төсөл шалгаруулалтыг зохион байгуулах этгээд**

2.1.Төсөл шалгаруулалтыг доор дурдсан эрх бүхий этгээд нь хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу зохион байгуулна:

2.1.1.төслийн захиалагч буюу эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

2.1.2.Диспетчерийн үндэсний төв;

2.1.3.сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит хуулийн этгээд;

2.1.4.төсөл шалгаруулалтын хороо буюу төсөл шалгаруулалтыг олон нийтэд зарлан, төсөл хэрэгжүүлэгчийг шалгаруулах чиг үүрэг бүхий энэ журмын дагуу томилогдох эрх бүхий этгээд.

2.2.Төслийн захиалагч нь төсөл шалгаруулалтыг зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй оролцоно:

2.2.1.төсөл шалгаруулалтаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг батлах;

2.2.2.төсөл шалгаруулалтын жишиг баримт бичгийг батлах;

2.2.3.төсөл шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий төсөл шалгаруулалтын хороог байгуулах;

2.2.4.төсөл хэрэгжүүлэх гэрээний загварыг боловсруулах,

батлах;

2.2.5.төсөл шалгаруулалтад шалгарсан оролцогчтой холбогдох гэрээ байгуулах;

2.2.6.шаардлагатай тохиолдолд төсөл шалгаруулалтын хорооны санал болгосноор үнэлгээний хугацааг нэг удаа 45 хүртэлх хоногоор сунгах.

2.3.Диспетчерийн үндэсний төв нь төсөл шалгаруулалтыг зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй оролцоно:

2.3.1.эрчим хүчний системийн судалгааг хийж, тухайн онуудад хэрэгжүүлэх хүчин чадал, байршлыг тодорхойлж, төслийн хэрэгцээ шаардлагын судалгааг төслийн захиалагчид жил бүр хүргүүлэх;

2.3.2.хэрэгцээ шаардлагад заасан төслийн нэгдсэн сүлжээнд үзүүлэх нөлөөлөл, горим тогтворжилтын тооцоо, дүгнэлт бусад шаардлагатай мэдээллээр төслийн захиалагчийг хангах;

2.3.3.шалгарсан төсөл хэрэгжүүлэгчтэй эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах.

2.4.Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит хуулийн этгээд нь төслийн шалгаруулалтад ашиглах төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон холбогдох бусад баримт бичгийг боловсруулна.

2.5.Төслийн захиалагч төсөл хэрэгжүүлэх тухай бүр төсөл шалгаруулах хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

2.6.Төсөл шалгаруулах хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх ба хараат бус гишүүн нь эрчим хүчний салбарт 7 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай, худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан, төрийн үйлчилгээнээс бусад салбарт ажилдаггүй байна.

2.7.Төсөл шалгаруулалтын хорооны хурал нь гишүүдийн 75-аас доошгүй хувь оролцсоноор хүчинтэйд тооцогдож, хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.8.Төсөл шалгаруулалтын хороо нь төсөл шалгаруулалтыг зохион байгуулахад дараах эрх, үүрэгтэй оролцоно:

2.8.1.төсөл шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, төслийн захиалагчаар батлуулах;

2.8.2.төслийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах;

2.8.3.энэ журмын дагуу төсөл шалгаруулалтыг зохион байгуулах;

2.8.4.төслийг шалгаруулсан тухай зөвлөмжийг гаргаж, төслийн захиалагчид хүргүүлэх;

2.8.5.төсөл шалгаруулалтын хорооны гишүүн нь үүрэгт ажлаа хараат бусаар хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;

2.8.6.энэ журмын 3.2.3-т заасан төсөл хэрэгжүүлэх баталгааны хэмжээг энэ журамд заасан хязгаарт батгаан тогтоох;

2.8.7 хуульд тогтоомжид заасан бусад.

### **Гурав.Төсөл шалгаруулалтыг нийтэд зарлах**

3.1.Төслийн захиалагч нь төсөл шалгаруулалтын урилгыг урьдчилсан үнэлгээ эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө өөрийн цахим хуудас болон олон улсад өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

3.2.Энэ журмын 3.1-д заасан хугацаанд төслийн захиалагчийн цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулах замаар оролцогч нарыг шалгаруулалтад оролцуулах бэлтгэл ажлыг хангана:

3.2.1.төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт;

3.2.2.ирүүлэх маягтын загвар;

3.2.3.төсөл хэрэгжүүлэх баталгаа, түүний хэмжээ нь санал болгож байгаа хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 1-5 хүртэл хувьтай тэнцүү байна;

3.2.4.энэ журмын 2.4-т заасан баримт бичгийг худалдан авах холбоос.

3.3.Энэ журмын 3.2.4-т заасны дагуу худалдан авах төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дараах мэдээллийг зайлшгүй тусгасан байна:

3.3.1.сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа;

3.3.2.тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг;

3.3.3.горим, тогтворжилтын тооцоо;

3.3.4.хөрөнгө оруулалт, эдийн засгийн шинжилгээ (WACC, IRR, NPV).

3.4.Энэ журмын 3.3-т заасан баримт бичгийг боловсруулсан зардлыг доор дурдсан аргачлалын дагуу тооцож, баримт бичгийг худалдан авах үнийг тодорхойлно:

$$\text{Зардал} = I + P \cdot q + L + T + G + C$$

I - суурь төлбөр - тавин мянган нэгж;

P - суурилагдсан хүчин чадал (Ватт);

q - итгэлцүүр (нарны цахилгаан станц-3, салхин цахилгаан станц-5);

L - газрын төлбөр;

T - Эрчим хүчний зохицуулах хорооноос олгох тусгай зөвшөөрлийн хураамж;

G - Горим, тогтворжилтын тооцооны төлбөр;

C - Бусад зардал (зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан зардал).

3.5.Төсөл шалгаруулалтын урилгыг нийтэд зарласнаас хойш төслийн үнэлгээний аргачлал, 3.2-т заасан бичиг баримт болон холбогдох бусад баримт бичигт өөрчлөлт оруулахгүй.

3.6.Төсөл шалгаруулалтын хороо нь төсөл шалгаруулалтын үйлчилгээний хөлс, шалгаруулалтад оролцох санал хүлээн авах хаяг, хугацаа зэрэг мэдээллийг зар дээр тодорхой бичнэ.

**Дөрөв.Төсөл шалгаруулалтад оролцох санал хүлээн авах**

4.1.Төслийн захиалагч нь төсөл шалгаруулалтын санал хүлээн авах, төсөл шалгаруулах цахим платформ бүхий мэдээллийн дэд бүтцийг бий болгож, үйл ажиллагаа явуулах найдвартай орчинг бүрдүүлсэн байна.

4.2.Оролцогч нь энэ журмын 3.1-д заасан хугацаанд урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтээ цахимаар хүргүүлэх ба нэг оролцогч нэг төсөлд санал ирүүлнэ.

4.3.Оролцогч нь урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтийн хамт хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, түншлэл бол түншлэлийн оролцогч хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар болон түншлэлийн гэрээ, талуудын сүүлийн 5 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн баталгаажуулсан хуулбар, туршлагын талаарх мэдээллийг ирүүлнэ.

**Тав.Төсөл шалгаруулалтыг зохион байгуулах**

5.1.Төсөл шалгаруулах хороо нь төсөл шалгаруулалтыг дараах үе шаттай зохион байгуулна:

5.1.1.урьдчилсан үнэлгээ;

5.1.2.техникийн үнэлгээ;

5.1.3.санхүүгийн үнэлгээ.

5.2.Урьдчилсан үнэлгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.2.1.төсөл шалгаруулалтын хороо нь энэ журмын 4.3-т заасан хүсэлтийг хүлээн авч, сүүлийн 5 жилийн ажлын туршлага, санхүүгийн чадавхийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй шаардлага хангасан оролцогчийн жагсаалтыг гаргана;

5.2.2.төсөл шалгаруулалтын хороо төслийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, урьдчилсан үнэлгээгээр өндөр оноо авсан эхний 5 хүртэл оролцогчийг эрэмблэн төслийн захиалагчид хүргүүлнэ;

5.2.3.төсөл шалгаруулалтын хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн төслийн захиалагч холбогдох шийдвэрийг гаргаж, тэнцсэн оролцогчийг дараагийн шатны шалгаруулалтад урина;

5.2.4.энэ журмын 5.2.3-т заасны дагуу шийдвэр гарсанаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгарсан оролцогч болон бусад оролцогчид урьдчилсан шалгаруулалтын шийдвэрийг цахимаар мэдэгдэж, тэнцсэн оролцогчийн талаар төслийн захиалагчийн цахим хуудас болон

олон улсад өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.3.Техникийн үнэлгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.3.1.Төсөл шалгаруулах хороо нь урьдчилсан үнэлгээний үе шатанд тэнцсэн оролцогчид дараах мэдээлэл бүхий санал ирүүлэх урилгыг цахимаар хүргүүлнэ:

5.3.1.1.төслийн нэр, суурилагдсан хүчин чадал, төсөл хэрэгжүүлэх байршил, техник, технологийн шийдэл, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний хэмжээ;

5.3.1.2.санхүүгийн болон хүний нөөцийн чадавхийн талаарх мэдээлэл, холбогдох зөвшөөрлүүд (тогтоосон маягтын дагуу);

5.3.1.3.үнийн санал (тогтоосон маягтын дагуу);

5.3.1.4.техникийн болон санхүүгийн санал боловсруулахад шаардлагатай мэдээлэл;

5.3.1.5.техникийн болон санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлт;

5.3.1.6.төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх нарийвчилсан төлөвлөгөө;

5.3.1.7.төсөл шалгаруулалт хүчингүй болох нөхцөл;

5.3.1.8.төсөл хэрэгжүүлэх гэрээний загвар;

5.3.1.9.эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загвар;

5.3.1.10.санал нээхээс өмнө тодруулга өгөх тухай;

5.3.1.11.төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа, хүлээн авах газар.

5.4.Оролцогч нь төслийн техникийн болон санхүүгийн саналыг тус тусад нь боловсруулж, цахимаар, тогтоосон хугацаанд ирүүлнэ.

5.5.Төсөл шалгаруулалтын хороо төслийн техникийн болон санхүүгийн саналыг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор үнэлнэ.

5.6.Техникийн саналд 70 болон түүнээс дээш хувь авсан оролцогчийн санхүүгийн саналыг нээнэ.

5.7.Санхүүгийн үнэлгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.7.1.төсөл шалгаруулалтын хороо оролцогчийн санхүүгийн саналыг эрэмбэлж, эх үүсвэрээс 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний хамгийн бага тариф (НӨАТ-гүй)-ын санал ирүүлсэн төслийг шалгаруулж, зөвлөмж, тайланг төслийн захиалагчид хүргүүлнэ;

5.7.2.энэ журмын 5.7.1-д заасан тайланд төслийн урьдчилсан шалгаруулалтын үнэлгээний талаар болон техник, санхүүгийн саналыг үнэлсэн тайланг тус тус дэлгэрэнгүй бэлтгэж, тусгана;

5.7.3.энэ журмын 5.7.1-д заасан зөвлөмж ирүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор төслийн захиалагч нь холбогдох шийдвэрийг зөвлөмжид үндэслэн гаргаж, шийдвэрийг техникийн болон санхүүгийн

санал ирүүлсэн оролцогчид тус тус мэдэгдэнэ.

**Зургаа.Шалгарсан оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулах**

6.1.Төслийн захиалагч төсөл нь шалгарсан оролцогчтой хэлцэл хийх ажлын хэсгийг байгуулж, энэ журмын 5.7.1-д заасан хамгийн бага тариф санал болгосон оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулна.

6.2.Шалгарсан оролцогч нь хэлцлийн явцад ирүүлсэн техникийн болон санхүүгийн саналаа өөрчлөхгүй.

6.3.Энэ журмын 6.1-д заасан оролцогчтой тохиролцоонд хүрээгүй бол уг хэлцлийг цуцалж, дараагийн бага тариф санал болгосон оролцогчийг хэлцэлд урина.

6.4.Энэ журмын 6.2-т заасныг зөрчсөн, 6.1, 6.3-т заасны дагуу тохиролцоонд хүрээгүй оролцогчийн төсөл хэрэгжүүлэх баталгааг буцаан олгохгүй.

6.5.Төсөл шалгаруулалтад шалгараагүй оролцогчийн төсөл хэрэгжүүлэх баталгааг төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор буцаан олгоно.

6.6.Төслийн захиалагч нь гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор дараах мэдээллийг цахим хуудсандаа байршуулна:

6.6.1.төсөл шалгаруулалтын баримт бичиг;

6.6.2.урьдчилсан үнэлгээнд төсөл ирүүлсэн оролцогчийн тоо;

6.6.3.урьдчилсан үнэлгээний шатанд шалгарсан оролцогчийн нэр;

6.6.4.төсөл шалгаруулалтын шатанд техникийн болон санхүүгийн санал ирүүлсэн оролцогчийн нэр;

6.6.5.санхүүгийн саналыг үнэлсэн оролцогчийн нэр;

6.6.6.төсөл нь шалгарсан оролцогчийн нэр, ирүүлсэн үнийн санал;

6.6.7.төсөл шалгаруулалтын хорооны гишүүдийн тухай.

6.7.Төсөл шалгаруулалт дууссаны дараа ирүүлсэн материалыг төслийн захиалагчийн архивт шилжүүлнэ.

**Долоо.Бусад**

7.1.Оролцогч нь урьдчилсан үнэлгээний, эсхүл эцэслэн шалгаруулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ журмын 5.2.4, 5.7.3-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор гомдлоо төслийн захиалагчид гаргана.

7.2.Төслийн захиалагч нь гомдлыг хүлээн авч ажлын 5 хоногт багтаан шалгаруулалтын материалтай танилцаж, дахин үнэлгээ хийх эсэх талаар шийдвэр гарган, энэ талаар цахим хуудсаар дамжуулан оролцогч нарт мэдэгдэнэ.

7.3.Төслийн захиалагч нь дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн бол холбогдох материалыг дахин үнэлж, шийдвэрийг энэ журмын 7.2-т

заасан мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 3 хоногт багтаан гаргаж, оролцогч нарт мэдэгдэнэ.

7.4. Энэ журмын 7.2-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол гаргасан этгээд нь холбогдох хуулийн дагуу шүүхэд хандана.

7.5. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.6. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 7364 дүгээрт бүртгэв.

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 9 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 23

Арвайхээр сум

### **ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 хэсгийн 11.3.3 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн аргын дулаан хэрэглэгч айл өрх, төсөвт болон хувийн хэвшлийн байгууллагуудад борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, хэрэглэгч айл өрхүүд, төсөвт болон хувийн хэвшлийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Өвөрхангай аймгийн Зохицуулах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зохицуулах зөвлөлийн дарга, орон тооны бус гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Д.АЛТАНСУВД

ГИШҮҮН  
ГИШҮҮ

Б.МӨНХБАТ  
О.ТӨМӨРЧӨДӨР

Өвөрхангай аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны  
09 дүгээр сарын 17-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт

**ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧ АЙЛ  
ӨРХ, ТӨСӨВТ БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД  
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

| №  | Сум, багийн нэр         | Тусгай зөвшөөрөл<br>эзэмшигчийн нэр               | Хэрэглэгчийн ангилал                                                                                    |                                            |
|----|-------------------------|---------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|
|    |                         |                                                   | Төсөвт<br>байгууллагад<br>болон үйлдвэр,<br>аж ахуйн нэгж<br>байгууллагад<br>борлуулах<br>дулааны тариф | Айл өрх-д<br>борлуулах<br>дулааны<br>тариф |
|    |                         |                                                   | /Эзэлхүүнээр тооцох тариф/<br>Төг/м.куб                      Төг/м.кв                                   |                                            |
| 1  | Нарийнтээл Баянтээг баг | Баянтээг ХХК                                      | 1288.1                                                                                                  | 750                                        |
| 2  | Нарийнтээл              | Эх нутгийн буян ХХК                               | 1288.1                                                                                                  | 750                                        |
| 3  | Хайрхандулаан           | Мэйжикалдаймонд ХХК                               | 1315.1                                                                                                  | 750                                        |
| 4  | Хайрхандулаан           | Таацын Алтан зам ХХК                              | 1315.1                                                                                                  | 750                                        |
| 5  | Баруунбаян Улаан        | Өв Баян Богд-Илч                                  | 1315.1                                                                                                  | 750                                        |
| 6  | Гучин-Ус                | Илчкасандра ХХК                                   | 1355.9                                                                                                  | 750                                        |
| 7  | Тарагт                  | Бүрэгтэй хайрхан                                  | 1491.5                                                                                                  | 750                                        |
| 8  | Арвайхээр               | Арвай-Илч ХХК                                     | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 9  | Арвайхээр               | Өв-ИЛЧ ХХК                                        | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 10 | Арвайхээр               | Газрын-Улаач ХХК                                  | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 11 | Арвайхээр               | Бага хайлантай ХХК                                | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 12 | Арвайхээр               | Мөнхбосго ХХК                                     | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 13 | Арвайхээр               | Хангамж-Орд ХХК                                   | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 14 | Арвайхээр               | Дэлгэрэх индустриал ХХК                           | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 15 | Арвайхээр               | Өв пост ХХК                                       | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 16 | Арвайхээр               | ЗХ-ний 256-р анги ХХК                             | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 17 | Арвайхээр               | Арвай плас ХХК                                    | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 18 | Арвайхээр               | Согоот-Илч ХХК                                    | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 19 | Арвайхээр               | Арвайн зам трасс ХХК                              | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 20 | Арвайхээр               | Онги-Ус суваг орон нутгийн<br>өмчийн оролцоот ХХК | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 21 | Төгрөг                  | Сод-Ээл ХХК                                       | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 22 | Уянга                   | Хан-Арвай ХХК                                     | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 23 | Уянгын жаргалант баг    | Баян Цэхч Хайрхан ХХК                             | 1491.5                                                                                                  | 850                                        |
| 24 | Богд                    | Приорити од гласс ХХК                             | 1491.5                                                                                                  | 900                                        |

|    |                |                       |        |      |
|----|----------------|-----------------------|--------|------|
| 25 | Зүүнбаян-Улаан | Мэйжикалдаймонд ХХК   | 1491.5 | 900  |
| 26 | Баянгол        | Онги-Илч ХХХ          | 1491.5 | 900  |
| 27 | Хужирт         | Хос-Их-Илч ХХК        | 1518.6 | 900  |
| 28 | Хужирт         | Өсөх гурвалжин ХХК    | 1518.6 | 900  |
| 29 | Хужирт         | Шунхлайн-Илч ХХК      | 1518.6 | 900  |
| 30 | Өлзийт         | Илчкасандра ХХК       | 1491.5 | 900  |
| 31 | Есөнзүйл       | Өв-Оюу-Илч ХХК        | 1491.5 | 900  |
| 32 | Сант           | Эс Эн кинг энерги ХХК | 1491.5 | 1000 |
| 33 | Баян-Өндөр     | БСНБ ХХК              | 1559.3 | 1000 |
| 34 | Бат-Өлзий      | Арвин бумба-Илч ХХК   | 1559.3 | 1000 |
| 35 | Бат-Өлзий      | Баян-Уулын буян ХХК   | 1559.3 | 1000 |
| 36 | Бүрд           | Өв дулаан             | 1559.3 | 1000 |
| 37 | Хархорин       | Ти Эс ти Ар ХХК       | 1559.3 | 1000 |
| 38 | Хархорин       | Арцот ХХК             | 1559.3 | 1000 |
| 39 | Хархорин       | Үнэт мөнгөл ХХК       | 1559.3 | 1000 |
| 40 | Хархорин       | Их ханхайн Овоо ХХК   | 1559.3 | 1000 |
| 41 | Хархорин       | Ачу-Эсү ХХК           | 1559.3 | 1000 |

## **ХОВД АЙМАГ ЦЭЦЭГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 9 дүгээр  
сарын 04-ний өдөр

Дугаар 13

Цэцэг нуур

### **ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 7.2.23, 8 дугаар зүйлийн 8.4 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.1, 9.2.2, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын хураамжийг батлагдсан тарифын дагуу албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдэд дагаж мөрдүүлэн, олон нийтэд сурталчлан таниулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж, Хог хаягдлын менежментийг сайжруулан, хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (Б.Баярсайхан), сумын Татварын Улсын байцаагч (Г.Сайнзаяа) нарт даалгасугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг сумын Засаг дарга (Б.Баярсайхан), Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Д.Золзаяа) нарт үүрэг болгосугай.

4.Тогтоол захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэгдэн, эмхэтгэлд нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Г. ГАНТУЛГА

*Ховд аймаг цэцэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн ээлжит 5-р  
Хуралдааны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

| №  | Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгч                                                       |              | Сарын хураамжийн хэмжээ /Төгрөгөөр/ |
|----|------------------------------------------------------------------------------------------------|--------------|-------------------------------------|
| 1  | Иргэн                                                                                          |              | 500                                 |
| 2  | Албан байгууллага /Төсвийн/                                                                    |              | 6400                                |
| 3  | Дулааны станц                                                                                  |              | 30600                               |
| 4  | Банк                                                                                           |              | 2100                                |
| 5  | Эмийн сан                                                                                      |              | 2100                                |
| 6  | Худалдаа үйлчилгээ эрхлэгчид                                                                   |              | 5300                                |
| 7  | Зочид буудал, амралтын газар,Ресторан, гуанз, кафе, караоке                                    |              | 7000                                |
| 8  | Талх, нарийн боов, хэрчсэн гурил, зайрмаг, цэвэр усны цех болон бусад жижиг үйлдвэрлэл эрхлэгч |              | 2100                                |
| 9  | Үсчин, ахуйн үйлчилгээ, оёдлын цех                                                             |              | 2100                                |
| 10 | Халуун усны газар                                                                              |              | 2100                                |
| 11 | Мал, мах махан бүтээгдэхүүн борлуулах газар                                                    |              | 10500                               |
| 12 | Шатахуун түгээх станц                                                                          |              | 2100                                |
| 13 | Дугуй засвар, авто угаалга, машин засвар                                                       |              | 7000                                |
| 14 | Нийтийн эзэмшлийн газар, гадаа талбайд худалдаа үйлчилгээ эрхэлдэг /явуулын/                   |              | 26000                               |
| 15 | Уул уурхайн туслан гүйцэтгэгч болон нүүрс тээврийн компани                                     | 39-өөс доош  | 66000                               |
|    |                                                                                                | 40-49 машин  | 99000                               |
|    |                                                                                                | 50-59 машин  | 132000                              |
|    |                                                                                                | 60-69 машин  | 165000                              |
|    |                                                                                                | 70-79 машин  | 198000                              |
|    |                                                                                                | 80-89 машин  | 231000                              |
|    |                                                                                                | 90-100 машин | 234000                              |
| 16 | Нүүрс тээврийн компаниудын ШТС                                                                 |              | 132000                              |

## **САНГИЙН САЙДЫН ТУШААЛ**

2025 оны 9 дүгээр  
сарын 03-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар  
хот

### **ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын “Маягт шинэчлэн батлах тухай” 2003 оны 49, “Маягт, журам шинэчлэн батлах тухай” 2012 оны 76, “Журам шинэчлэн батлах тухай” 2012 оны 276, “Журам батлах тухай” 2013 оны 73 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн сангийн газар /Б.Цогбадрах/-т даалгасугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд  
2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан.*

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар А/479

Сүхбаатар сум

### **ЗАХИРАМЖ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 09 дугаартай “Журам батлах тухай” захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй байх тул захирамжийг хүчингүй болгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Саруултөгс)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЛХАГВАДОРЖ

**ТЭМДЭГЛЭЛ**